



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/552

Хэрлэн сум

Уулзалт зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлтийг сонсох уулзалт зохион байгуулахад 2,304,600 (хоёр сая гурван зуун мянга дөрвөн мянга зургаан зуун ) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 11 дугаар сарын 02-ны  
А.Н.С.З. дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Томилолт	5 хүн * 4 хоног	64,000	1,024,000
2	Шатахуун (дизель)	1685 км *337л	3,800	1,280,600
Дүн				2,304,600